



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/410

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.4, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймагт зохиогдсон Монголын хүүхдийн спортын VII наадамд оролцох 134 өсвөрийн тамирчдад дэмжлэг үзүүлсүгэй.


2.Дэмжлэгт шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



... (שם הרישום) • רישום / תאריך • תאריך / שם (השם - תאריך) זה יבנה בהתאמה ...

... (שם הרישום) • רישום / תאריך • תאריך / שם (השם - תאריך) זה יבנה בהתאמה ...

... (שם הרישום) • רישום / תאריך • תאריך / שם (השם - תאריך) זה יבנה בהתאמה ...

... (שם הרישום) • רישום / תאריך • תאריך / שם (השם - תאריך) זה יבנה בהתאמה ...

... (שם הרישום) • רישום / תאריך • תאריך / שם (השם - תאריך) זה יבנה בהתאמה ...

משרד המשפטים

Handwritten signature and date in blue ink.

Handwritten signature in blue ink.

Handwritten text in blue ink.



משרד המשפטים
רשמת הרישום - תאריך / שם